МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 20 өдөр Дугаар А/522 Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн хугацаанд тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн арван тавдугаар хурлын шийдвэрийг холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газар /Б.Батбаяр/-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар /О.Энхболд/-т даалгасугай.

САЙД Т.МӨНХСАЙХАН

141242389

Эрүүл мэндийн сайдын 2024 оны
12 дугаар сарын 20-ны өдрийн
А/566 дугаар тушаалын хавсралт

## МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРС

| № | Эрүүл мэндийн байгууллагын нэрс | Батламжийн дугаар | Магадлан итгэмжлэгдсэн хугацаа | Магадлан итгэмжлэл эхлэх огноо | Магадлан итгэмжлэл дуусах огноо |
|---|---|---|---|---|---|
| 1. | Улаанбаатар хот, Далд засал ХХК-ийн сувилал | 322/2024 | 3 жил | 2025.01.01 | 2027.01.01 |
| 2. | Улаанбаатар хот, "Жаргалант" сэргээн засах төв 113 дугаар анги | 323/2024 | 2 жил | 2024.12.04 | 2026.12.04 |
| 3. | Улаанбаатар хот, Сод топаз ХХК-ийн Топаз эмнэлэг | 324/2024 | 3 жил | 2024.12.23 | 2027.12.23 |
| 4. | Говь-Алтай аймаг, Чандмань сумын эрүүл мэндийн төв | 325/2024 | 2 жил | 2024.12.21 | 2026.12.21 |
| 5. | Говь-Алтай аймаг, Шарга сумын эрүүл мэндийн төв | 326/2024 | 2 жил | 2024.12.21 | 2026.12.21 |